

## ШААЗАН ХОТЫГ СУРВАЛЖИЛСАН НЬ

**Д.Баяр**

*Шинжлэх ухааны академи, Түүхийн хүрээлэн*

**Түлхүүр үг:** Шаазан, турь, суурин, Онги, Өгөөдэй

Өвөрхангай аймгийн Баянгол сумын нутаг, Онгийн голын баруун биед Шаазан хот хэмээх эртний нэгэн балгасын турь оршдог. 1998 онд тус балгас хийгээд ойр орчмын холбогдох бусад дурсгалыг хайгуулын журмаар судлан үзэх завшаан олдсон бөгөөд энэ тухай тус тэмдэглэлд тодруулан өгүүлэхийг зорилоо.

**Судлагдсан байдал.** Энэхүү турийн талаар Х.Пэрлээ авгай ном бүтээлдээ дурдсан зүйл байгааг үзэхүл, тэрвээр дурдсан хотын турийг гүймэг шинжин тодорхойлолт бичиж, тойм зураг үйлдэн зарим түүвэр олдворын зүйлс цуглуулж байжээ. Тэрвээр уг турийг Дундговь аймгийн Сайхан овоо сумын нутаг Харгалын (Онгийн) голд бий гэж өгүүлсэн ба тэндээс Юан улсын үед холбогдох шаазангийн хагархай болон 1064-1066, 1078-1085 оны үеийн зоос олдогоос үндэслэн Юан улсын үеийн төмөрчин, ваарчин, гар урчууд сууж байсан хот бололтой гэж үзсэн ажээ<sup>1</sup>. Түүнчлэн тэрвээр, уг орд хэнд харъяалагдах, ямар учиртай хот болох талаар "Онгийн ордонд Өгөөдэй хаан өвөлждөг байсан тул, тэр орд эрхбиш Хангай талд байсан болов уу гэж бодогдох юм. "Шаазан хот" говь талдаа байна"<sup>2</sup> гэж өгүүлжээ.

Тус тэмдэглэлийг бичигч нь 1998 онд, тухайн үед Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнд томилолтоор ажилаж байсан Япон улсын археологич Н.Шираиши, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баттулга, ЮНЕСКО-ийн Монгол дахь Үндэсний комиссын дарга Н.Уртнасан нарын хамтаар тус хотын турийг хайгуулын журмаар шинжин үзэж тодорхойлон, тойм зураг үйлдэх, зарим түүвэр олдвор цуглуулах зэрэг ажлыг хамтран гүйцэтгэсэн болно<sup>3</sup>. Энэхүү судалгааны үр дүн Н.Шираишийн нийтлүүлсэн "Чингис хааны үеийг археологийн талаар судлах нь" хэмээх нэгэн сэдэвт бүтээлд тусгагджээ.<sup>4</sup>

Түүнчлэн "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал" хэмээх сэдэвчилсэн лавлахын хот суурины тухай хэсэгт энэхүү Шаазан хотын тухай товч өгүүллийг Б.Цогтбаатар бичсэн байна<sup>5</sup>.

**Шаазан хот.** Энэхүү Шаазан хот хэмээх турь нь Өвөрхангай аймгийн Баянгол сумын төвөөс зүүн урагш, Дундговь аймгийн Сайхан овоо сумын нутагтай залгаа, эл хоёр сумын уулзвар зааг болох говийн элсэрхэг хөрстэй, харгана бут ихтэй тал газарт байна. Дээхнэ үед энэ нутаг Дундговийн Сайхан овоо суманд харъяалагдаж байжээ.

Турийн ерөнхий байдал гэвэл, Онгийн голын баруунтай, голоосоо 400 гаруй м зайтай баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон гонзгой дөрвөлжин хэлбэртэй бөгөөд тойрон хүрээлсэн ерөнхий хэрмийн ор огт мэдэгдэхгүй. Хойноос урагш чиглэлтэй нэг их урт гудамж, түүний хойд үзүүртэй залгалдан хөндлөн байрласан өөр нэг гудамжтай. Эдгээр гудамжны хоёр талаар даган байрласан байшин барилгын ором болох тодорхой хэлбэр дүрс бүхий овгоруудтай.

Хоёр гудамжийг дагаж зохион байгуулалттай байрласан барилгын ором бүхий хэсгийн хэмжээ хойноос урагш 440 м орчим, баруунаас зүүн тийш 300 м орчим байна. Үүнээс гадна энэхүү шигүү барилгатай хэсгээс тусдаа ганц нэг

<sup>1</sup> Пэрлээ Х. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь, талын нутгаар эртний судлалын хайгуул хийсэн нь. Эртний судлал-угсаатны зүйн бүтээл. SA, Т. II, f.4. УБ., 1963, 33-34-р тал

<sup>2</sup> Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961, 103-р тал

<sup>3</sup> Шаазан хотын турийг судлах шинжилгээний хэсгийн тайлан. 1998 он. ТХГБС

<sup>4</sup> Shiraishi N. Chingisukan no Kokogaku. 2001

<sup>5</sup> Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал. Сэдэвчилсэн лавлах. УБ., 1999, 200-р тал

томоохон барилгын ор үлдэгдэл өмнөд, хойд захад уг шигүү барилгуудаас 100 м гаруй зайд мэдэгдэхээс гадна уг суурингийн зүүн буюу Онгийн голын талд мөн баруун хойноос зүүн урагш цувран байрласан дөрвөн барилгын ором мэдэгднэ.

Турийн гадарга дээгүүр олдвор хайж үзвээс, хөрсөн дээгүүр өнгө өнгийн паалантай вааран сав суулгын хагархай болон тоосгоны хэлтэрхий элбэг тохиолдно. Бүтэн тоосго огт тааралдахгүй, олдож буй тал тоосгыг хэмжиж үзэхэд 16 см өргөн, 5 см зузаантай байна. Бусдаас тодорхой ялгарах нэг барилгын ормын дээр баганын засмал чулуун суурь байх ажээ. Эндээс олдож буй шаазан савын дотор Юан улсын үед холбогдох Чин Яо хэмээх бараан сүүдэртэй, тод цагаан цэнхэрдүү өнгийн шаазан, селадон хэмээх ногоон паалантай шаазан савын үлдэгдэл нэлээд олдож байна. Түүнчлэн тээрмийн ширмэн цөнгийн хагархайнууд, зоос, барилгын дээврийн ваарын жижиг хэлтэрхий зэрэг зүйл таарч байлаа. Зоос мөнгөний зүйлс нь Kaiyuan Tongbao (621-907), Xiangfu Tongbao (1008-1017), Tiansheng Yuanbao (1023-1032), Zhihe Yuanbao (1054-1056), Ximing Yuanbao (1068-1078), Yuan you Tongbao (1086-1094), Yuanfu Tongbao (1098-1100), Zhenghe Tongbao (1111-1118) зэрэг зоос байна.

Энэхүү турийн харалдаа, Онгийн голын эргийг дагаж харгана их ургасан байх ба морьтой хүнээс ч өндөр, холоос харахад бургасан шугуй мэт харагддаг. Иймээс Онгийн голыг энэ хэсэгт нь Харганы гол гэж нэрлэдэг байна. Голын эргийн энэхүү харганын дотор, Шаазан хотын туриас олддогийн адил шаазан, шавар сав суулгын хагархай мөн их олдох ажээ. Харин энд ямарваа барилга байшингийн ор үлдэгдэл байхгүй юм. Нутгийн хүмүүс энэ харганыг Шаазан хотын турьтай холбож ярих бөгөөд эрт цагт энд үзэм тарьдаг байсны үлдэгдэл энэ гэдэг.

Монгол их гүрний үед холбогдох олдвор бүхий суурин газар болон барилга байшингийн ор үлдэгдэл Монголын говь талын нутгаар багагүй тохиолддог нь түүх сударт тэмдэглэн үлдээсэн ямарваа мэдээ баримт үгүй боловч нутгийн ардын дунд ам дамжин хэлцсээр ирсэн домог түүхтэй байх нь олонтой.

Харин энд яригдаж буй Шаазан хоттой холбон үзэж болох мэдээ баримт Монголын түүхийн зарим сурвалжид хадгалагдан үлдсэн нь тун ч олзуурхуштай юм. Тухайлбал Рашид ад Диний эрхлэн зохиолгосон "Судрын чуулган" хэмээх түүхэн тэмдэглэлийн доторхи Өгөөдэй хааны үйл амьдралын талаар өгүүлсэн хэсэгт, "Намрын цагт тэрвээр Хар Хорумаас дөрвөн өдөрчийн газарт орших Кушенор очиж 40 хоног мацаг барина. Өвөлжөө нь Онг хин; тэрвээр Буленку, Джаленку зэрэг уулсаар ан авлаж өвлийг тэнд өнгөрөөдөг. Ерөнхийдээ түүний хаваржаа Хар Хорумын хавь газраар, зуны билчээр нь ..., намартаа Куше нороос эхлэн, Хар Хорумаас ганц өдөрчийн зайтай Усун кулд байдаг, харин өвөлжөө нь Онг хин"<sup>6</sup> гэжээ.

Түүнчлэн энэхүү "Онг хин" хэмээх өвөлжөөний газарт мод болон шавраар хоёр өдөр явах хэмжээний урттай хүрээ хийж, дотор нь ан гөрөөсийг хөөн оруулж агнадаг байсан тухай өгүүлжээ<sup>7</sup>.


Мөнх хаан, хаан ор залгасныхаа дараа "Онг ки" хэмээх газарт өвөлжсөн тухай мөн "Судрын чуулганд" мэдээ бий<sup>8</sup>.

Түүхэн сурвалжид гарч буй эдгээр мэдээнээс Өгөөдэй хаан Хар Хорум орчимд хавар, намрыг өнгөрөөдөг, зуслангийн газрын нэр тодорхойгүй, харин "Онг хин" хэмээх газарт өвөлждөг, тэндээ ав хомрого хийдэг байсан гэх мэтийн зүйл тодорхой болж байна. Түүнчлэн Өгөөдэйгээс хойших үед ч энд хаадын өвөлжөөний газар байсан болох нь Мөнх хаан мөн Онгийн гэдэг газарт өвөлжиж байсан гэдгээс лавтай мэдэгдэж байна.

<sup>6</sup> Рашид ад Дин. Сборник летописей. Т. II. Перевод с персидского Ю.П.Верховского, примечания Ю.П.Верховского и Б.И.Панкратова, редакция проф. И.П.Петрушевского. М-Л., 1960, с.41

<sup>7</sup> Мөн тэнд. 41-42-р тал

<sup>8</sup> Мөн тэнд. 144-р тал



The map showing the plan of Shaazan-Khot site.  
(Bayan-Gol county, Övörkhangaï prefecture, MONGOLIA)  
Survey: June 09, 1998  
Surveyor: N. SHIRAISHI D. BAYAR Ts. BATTULGA  
Drawing: N. SHIRAISHI

Шаазан хотын турь

Түүхэн тэмдэглэлд хадгалагдан үлдсэн эдгээр нэрсийг өнөөгийн газар орны нэрстэй сайтар тулган харьцуулж нягтлахын хамт дурдсан нутагт хадгалагдаж үлдсэн эртний хот суурины дурсгал бүгдийг сурвалжлан олж он цагийг тодорхойлон, газрын зурагт байрлуулж нарийн судалгаа хийсний дүнд эдгээр асуудлыг бүрэн тодруулах боломжтой.

Тийм ч учраас бид энэ нутгийн газар усны нэрсийг холбогдох домог яриа сэлтийн хамтаар сураглан тодруулж, эртний сурвалжид хадгалагдан үлдсэн нэрстэй адилтган жишихийг зорьсон юм.

Түүхэн сурвалжид тохиолдож буй Онгийн гол дахь өвлийн орд, түүний орчмын газар усны нэрсийг одоогийн газар нутгийн нэрстэй харьцуулан дүйлгэх оролдлого өмнө ч гарч байсан бөгөөд эрдэмтэн Ж.А.Бойл, Рашид ад Диний өгүүлсэн Буленку, Джеланку хэмээх уулсыг Говийн Алтайн Гурван Богд, Гурван Сайхан уулстай адилтгаж үзсэн байна<sup>9</sup>.

Бид энэ нутгийн газар усны нэрсийг сураглан тодруулж үзэхэд Монголын дундад зууны түүхэн сурвалжид гардаг зарим нэрстэй дүйлгэж болох зүйлс тохиолдож байгаа нь сонирхолтой юм. Тухайлбал, Чан Чун аршийн замын тэмдэглэлд тэрвээр Улаан Чих хэмээх уулын дэргэдүүр өнгөрсөн тухайгаа өгүүлсэн байдаг<sup>10</sup>. Тэгвэл дурдсан нутгийн газар усны нэрийн дотор Улаан чих нэртэй уул хоёронтаа таарав. Үүнд, тус сумын нутаг Өнцийн ар луу, сумын төвөөс баруун хойш дөчөөд км зайтай Улаан чих гэж уул байх ба үүнийг мөн Чих хайрхан гэдэг гэнэ. Бид аян зам хөөж явахдаа холоос энэ уулын барааг харж билээ. Мөн үүнээс гадна Сант сумын нутаг, сумын төвөөс зүүн урагш 30 орчим км-т Эрдэнэдалай, Сант хоёрын зааг нутагт бас Улаан чих гэж уул бий гэнэ. Энэ нь хэдийгээр бидний сонирхон бүхий Онгийн голын ордтой шууд холбоогүй боловч түүхэн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн нэр болохын хувьд мөн л цаашид нягтлан судлууштай зүйл юм.

Энд олж сонссон газар усны нэрсийн дотор онц сонирхол татаж буй нь Шаазантаас зүүн урагш арваад км зайтай Булан хулгар гэж газар байдаг хэмээх мэдээ байгаа нь дээрх "Судрын чуулганд" нэр гарах, Өгөөдэй хаан авлахдаа дайран өнгөрдөг байсан Буленку хэмээн тэмдэглэгдсэн газрын нэртэй их л төстэй байгаа нь цаашид зайлшгүй лавлан нягтлууштай санагдсан болно.

Эртний хүмүүс хот суурин байгуулж, жилийн тодорхой улиралд тогтвортой оршин суухад эрхбиш тухайн нутаг орны байгал, цаг агаарын нөхцлийг харгалзан үзсэн байх ёстой. Иймээс бид энэ нутгийн цаг агаарын байдал нь өвлийн цагт хүн оршин суух боломжтой эсэхийг тодруулах оролдлого хийсэн юм. Тус Баянгол сумын нутагт 1987, 1988, 1989, 1991 оны 1-р сарын цаг агаар 1-аас  $-35,5$ , дундач хэмжээ нь  $-15,5$  –аас  $-21,7$  байжээ. Энэ дурдсан дөрвөн жилд зарим жил цасгүй байхад зарим жилд 42 см зузаан цастай байсан байна. Баруун-хойд -баруун –хойд чиглэлийн салхи голлох ба салхины дундач хурд  $5-8$  м/сек байжээ. Үүнээс үзэхэд тус нутаг орны цаг агаарын байдал өвлийн улиралд тун ч тогтворгүй, зарим жил огт хуурай байхад заримдаа хур тундас ихтэй, харин салхины хувьд говь тал нутаг учраас нөмөр нөөлгө багатай, задгай салхитай, суурьшин амьдрахад боломж муутай байна. Гэвч тус нутгийн цаг агаар өнгөрсөн 700 гаруй жилийн хугацаанд ямар байдлаас хэрхэн яаж хувирсан нь тодорхойгүй, ер нь Төв Азийн цаг уурын нөхцөл байдал ямагт хувьсан өөрчлөгдөж байдаг, үүнийг дагалдаад нүүдэлчдийн амьдрал байдал, нүүдэл хөдөлгөөнд их өөрчлөлтүүд гардаг зэргийг харгалзан үзвэл тэр цагт энд хүн суурьшин амьдрах боломжтой нөхцөл бүрдэж байсан гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Тус нутгийн настан буурлуудын яриагаар (энэ сумын оршин суугч Ширчинданзангийн Самдан, түүний гэргий Цэдэнгомбын Дэгэдбалжир нараас мэдээллийг авлаа) энэ хавийг дайраад урагш явсан зам байдаг нь Хар

<sup>9</sup> John Andrew Boyle. The Mongol World Empire 1206-1370. London 19778 p.150

<sup>10</sup> Си Ю Цзи или описание путешествия на Запад. Труды членов Российской Духовной Миссии в Пекине. Т.IV, СПб., 1866

Хориноос ирээд Хөх хот ордог бөгөөд энэ нь эртний Их Монгол улсын үеийн юм байж мэдэх талтай ажээ. Учир нь энэ бол Харчин өртөөний замаас тусдаа бөгөөд Тасархайн дэнж, Эрүүний бууцаар гарч Халцгайгаар явдаг ба энэ нь мөн Шаазант хэмээх эртний буурийг бас дайрдаг гэнэ. Тэгээд ч энд хүн суурьшин амьдарч байсны биет гэрч болох эртний хот суурин газрын үлдэгдэл, тэдгээртэй холбоотой домог яриа тэргүүтэн хадгалагдан үлдсэн нь тус газарт үнэхээр Монголын их хаадын өвлийн орд байсан гэдгийг үгүйсгэхгүй бөгөөд энэ нь цаашдын нарийвчилсан судалгаагаар лавтай тогтоогдох буй заа.

#### **Хайгуулаар үзэж тэмдэглэсэн бусад дурсгал**

**Түрэгийн хашлага чулуу.** Шаазан хотын туриас урагш 5-6 км-т голын өндөр тэгш дэнжид түрэгийн үеийн нэгэн хашлага чулууны үлдэгдэл байна. Энэ нь тухайн үеийн тахилын байгууламж болох дөрвөн хавтант хашлага байсны үлдэгдэл болох хоёр хавтан чулуу газарт зоолттой байх ба нэг нь газраас нэлээд өндөр цухуйжээ. Нарийн хэмжилт хийж, зурж амжаагүй. Нутгийнхан үүнийг босоо чулуу гэж ярьж байв.

**Шаазант.** Баянгол сумын төвөөс зүүн хойш 20 орчим км зайтай, Онгийн голын зүүнтэй 6-7 км-т Шаазант хэмээх нэртэй нэгэн газар бий. Яг энэ газрыг Шаазантын хоолой гэх ба энэ хавийг нийтэд нь Олон худаг гэдэг. Энд буй багийн төвийг Луудайн баг гэдэг ажээ.

Эл газар нь ерөнхийдөө тэгш талархаг, бут дэрс нэлээд ургасан бөгөөд энэхүү нам тэгш хэсгийг захалсан яльгүй өндөр тэгш дэнжийн өврөөр шаазан савны хэлтэрхий элбэг олох ба үүний төв хэсэгт барилгын ор үлдэгдэл бололтой төвгөр, түүний дээгүүр шаазан савны хэлтэрхий их олдож байна. Мөн баганын суурь чулуу байгаа нь 63x62,5x18 см хэмжээтэй бөгөөд энэ нь Сүн улсын хэмжээгээр 2 чи болой. Суурь чулууг хар толботой саарал боржингоор хийсэн ба голдоо жижиг хонхортой. Газрын гадаргууд ил хэвтэх зарим олдворын зүйл түүвэрлэж авсан болно. Үүнд, гадуураа хүрэн паалантай, том амсартай ваар савны амсрын хоёр хэсэг том хагархай, 10-11 см голч бүхий бутан савны ёроол хэсэг, их бие нь гадуураа цагаан паалантай байсан бололтой хонхойлж хэвлэсэн тал саран хэлбэрт зэрэгцээ хос дүрс бүхий тоосгоны хэлтэрхий, үүний зузаан 4 см.

Өгүүлэн бүхий Шаазантын талаар эрдэм шинжилгээний ном зохиолд дурдсан зүйл үгүйн учир урьд өмнө судалж байсангүй бололтой. Энэ хавийн газарт гамин (чандруу) алсан юм гэнэлээ гэж ярьдаг.

**Дөрвөлжин.** Баянгол сумын төвөөс баруун хойш Баруун цагаан булан гэдэг газарт "Дөрвөлжин" хэмээх хоосон цулгүй, гонзгой дөрвөлжин хэлбэртэй жижиг шорон хэрэм байхыг үзэв. Дээгүүр нь машин зам дайран гарсан байх ба гадарга дээгүүрээ ямарваа ил мэдэгдэх олдворын зүйл үгүй.

**Мазар (Базар) хот.** Өвөрхангай аймгийн Төгрөг, Тарагт сумдын завсар нутагт (Урьд нь Тарагтын нутаг байсан, одоо Төгрөгийнх) Мазар буюу Базар хот гэж нэрлэдэг, эртний шаазан савны хэлтэрхий их олддог суурин газрын үлдэгдэл байдаг. Үүнийг анх Х.Пэрлээ авгай мэдээлэн бичиж, эндээс олддог сав суулганы хагархай, ширмэн тогооны хөл, зоос (1068-1077 оны) зэрэгт үндэслэн XIII-XIV зууны үед холбогдуулан үзжээ<sup>11</sup>.

Уг дурсгал нь Өвөрхангай аймгийн Тарагт сумын төвөөс хойш хориод км зайтай орших ба энд Хар Хорины салбар тариа ногоо тарих тасаг оршдог. Энэхүү эртний үлдэгдэл нь газрын гадарга дээр хэрэм, барилга гэмээр овойж товойж тодорхой мэдэгдэх зүйлгүй хэсэг уудам талбай бөгөөд тун нарийн сайн шинжиж, агаарын болон топо зураглал хийх шаардлагатай. Гадарга дээрээс нь хот суурин газарт холбогдох барилгын тоосго, сав суулганы хагархай, мөн зоос олддог гэж нутгийнхан ярьдаг. Хайгуул судалгаа хийж үзвээс зарим тоосгоны зүйл олдож байв. Үүнд, цайвар саарал өнгийн зөөлөн тоосго байгаа нь уртын хэмжээ

<sup>11</sup> Пэрлээ Х. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын..... 35-р тал

мэдэгдэхгүй, өргөн 15 см, зузаан 4,5 см байхын хамт хатуу хөх тоосго буйн хэмжээ мөн урт нь мэдэгдэхгүй, өргөн 12 см, зузаан 4,5 см байна.

Энэ эртний суурингийн талаар нутгийн оршин суугчдаас сураглахад, энд бичигтэй чулуу байсан нь одоо алга болсон, түүнчлэн эндээс дүгрэг, дөрвөлжин хэлбэртэй тээрмийн чулуу олдож байсныг эргүүлж булсан, харин дөрвөлжин нь одоо ногооны бригадад бий, мөн эндээс зоос их олддог байсан нь одоо олдохоо больсон, урьд энд үзэм тарьж байсан гэдэг гэхчлэн сонирхолтой зүйлсийг нутгийн оршин суугч 78 настай Сэрчинданзангийн Мааниас олж сонслоо.

**Зоост.** Мазараас зүүн тийш 5-6 км зайтай Зоост хэмээх газар байна. Энэ нь баруунаас зүүн тийш сунасан гонзгой дөрвөлжин хэлбэртэй товгор дэвсэг газар бөгөөд зүүн үзүүртээ хөшөө мэт босоо чулуутай. Эндхийн газрын гадарга дээгүүр тоосго, дээврийн ваарын хагархай их байна. Тоосгоны байдал, хар хөх өнгөтэй хатуу нягт болон цайвар саарал гэсэн хоёр төрөл байна. Цайвар тоосгоны зузаан 4-4,5 см, нэг бүтэн тоосго 4,5x14x27,5 см байгаа нь их л шинэхэн мэт сэтгэгдэл төрүүлэв. Дээрх товгороос хойш 70 м орчим зайд хэсэг чулуу овоорон тархсан газар буйн дээгүүр мөн тоосго их байгаа нь тун ч шинэхэн мэт санагдана. Түүнээс хойхно нэгэн хэсэг их чулуутай, булш гэхэд чулуу нь арай таруу байдалтай газар байна. Нутгийнхны яриагаар энэхүү Зоостод нэг хятад сууж байсан гэх ба ер нь энэ нутагт буй эртний хот суурин газрын үлдцийг ихэвчлэн хятадтай холбож үздэг юм байна.

Энэхүү хайгуул судалгааны ажлын дүнд Монгол гүрний үед холбогдох, зарим нь урьд өмнө манай судлаачдын хараа сонорт аль нэгэн хэмжээгээр өртөж судлагдсан, зарим нь ч судалгааны хүрээнд хамрагдаж байгаагүй хот суурины үлдэгдлийг гүймэг шинжин үзэж судалгааны эргэлтэд оруулахыг зорьсон бөгөөд энэ нь цаашид Монгол орны эртний хот суурин, тэр тусмаа говь талын нутгаар орших суурьшмал амьдралын холбогдолт дурсгалыг судлан шинжихэд бага ч болов хувь нэмрийг оруулах болов уу хэмээн найдна.

## Резюме

Д.Баяр. Институт Археологии, Академии Наук Монголии

### Обследование древнего поселения Шаазан хот

*В 1998 году были обследованы остатки древнего поселения "Шаазан хот", находившееся на стыке границ Убурхангайского и Среднегобийского аймаков у р. Онгийн, в гобийской ее части. Оно представляет собой неукрепленное оборонительным валом поселение имеющее 2 главные улицы, вдоль которых заметны остатки зданий. Среди подъемного материала с территории поселения имеются обломки кирпичей и керамических сосудов Юаньской эпохи и также монеты, относящиеся к различным периодам истории, начиная с VII века вплоть до XII века.*

*Данный памятник интересен тем, что его можно связывать с историческими сведениями, сохранившихся в письменных источниках. Так, у Рашид ад Дина отмечено, что Угэдэй и Мункэ хаган имели зимнюю ставку в местности Онкин или Онхин, где они занимались охотой. Вполне возможно, что данное поселение находящееся на берегу р. Онгийн является зимней ставкой Великих Монгольских хаганов.*